



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 1/09

Сүмбэр сүм

Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн
урамшуулал олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 55 дугаар зүйлийн 55.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрмийн 3.3.7, 3.3.10 дахь заалтууд, тус хэлтсийн албан хаагчдын 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн үнэлгээг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгээр хангалттай болон түүнээс дээш үнэлэгдсэн албан хаагчдад олгох мөнгөн урамшууллын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Төрийн жинхэнэ албан хаагчдад олгох мөнгөн урамшууллыг цалингийн сангаас тооцон олгохыг Ахлах нягтлан бодогч /Ч.Нарангэрэл/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ө.МАНЖИЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/01

Сүмбэр сум

Албан хаагчдын цалинг шинэчлэн
тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4 дэх элэлт, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1-р хавсралт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын "Орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрэм"-ийн 3.3.7, 3.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн хавсралтаар баталсугай
2. Хавсралтаар батлагдсан албан хаагчдад цалингийн сангаас зохих цалин хөлсийг шинэчлэн тооцож олгохыг ахлах нягтлан бодогч М.Нарангэрэл-д зөвшөөрсүгэй.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус хэлтсийн даргын 2020 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ө.МАНЖИЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐2᠒ оны ᠑᠑ сарын ᠒1 өдөр

Дугаар ᠕/᠒᠒

Сүмбэр туг

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хэвсрэлт, "Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрэм"-ийн 3.3.7, 3.3.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хэлтсийн төрийн үйлчилгээний албан хаагчдын 2020 оны 04 дүгээр сарын ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдэл олгох албан хаагчдын нэр хувь хэмжээг хэвсрэлтээр баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг хэвсрэлтэд заасны дагуу тооцож, цалингийн сангаас олгохыг Ахлах нягтлан бодогч М.Нарангэрэл-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ө.МАНЖИЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/н

Сүмбэр С

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хэлтсийн төрийн үйлчилгээний албан хаагчдын 2020 оны 05 дугаар сарын ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдэл олгох албан хаагчдын нэр хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг хавсралтад заасны дагуу тооцож, цалингийн сангаас олгохыг Ахлах нягтлан бодогч /Ч.Нарангэрэл/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ө.МАНЖИЛ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 413

Сүмбэр сү

Урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага шалгуур журмын 5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, санхүүгийн тайлангуудыг хууль тогтоомжид заасан хугацаанд стандартын дагуу үнэн ивэе гаргаж, 2019 оны жилийн эцсийн тайланд хийсэн Төрийн аудитын газрын дүгнэлтээр УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдэж, "Зөрчилгүй санал дүгнэлт"-тэй ажилласан Ахлах нягтлан бодогч /Ч.Нарангэрэл/-ийг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний цалингаар шагнасугай.

2. Урамшууллын нийт 797.676 /Долоон зуун ерэн долоон мянга зургаан зуун далан зургаан/ төгрөгийн зардлыг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Ч.Нарангэрэл/-д зөвшөөрсүгэй.

ДАРГ  Ө.МАНЖИЛ
4615402 4211109110